

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/089/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Э.Энхбүрэн: Утас: 7036-2442 Цахим хаяг: Enkhburene@audit.gov.mn
---	---

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	17-19
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18-19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНСДИТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУИХ	Монгол улсын Их хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОХУ	Оросын холбооны улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.САРАНЧИМЭГ ТАНАА**

2025-02-25 № СЭА-2025/089/НА-СТА-ТЦЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус байгууллагын төрийн захиргааны 27 албан хаагчид хөдөө, орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 201,455.8 мянган төгрөгийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд ОХУ-тай хил залгаа орших сумдын иргэдэд үйлчилгээг ойртуулан Ерөө, Түшиг, Хүдэр, Цагааннуур, сумдад Монгол улс ОХУ-ын хилийг цааш, нааш нэг удаа нэвтрэх эрхийн үнэмлэх, гадаадад зорчих эрхийг нээн 21137 үнэмлэх олгож, улсын төсөвт 63,411.0 мянган төгрөгийн үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г 2 зорилго 9 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 97.1 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	100,899,708.00	158,277,036.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	152,182.80
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	152,182.80
3121	Төгрөг	00.00	152,182.80
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	152,182.80
33	АВЛАГА	00.00	00.00
33100	Ажиллагсадтай холбоотой авлага	00.00	10,557,997.99
35	БАРАА МАТЕРИАЛ	100,899,708.00	147,566,856.00
351	Түүхий эд материал	48,641,598.00	80,751,551.00
35110	Тусгай зориулалттай материал	48,641,598.00	80,751,551.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	10,552,870.00	11,602,280.00
354	Хангамжийн материал	41,705,240.00	55,213,025.00
35410	Бичиг хэргийн материал	3,249,165.00	14,353,000.00
35420	Аж ахуйн материал	24,956,725.00	25,511,225.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,924,950.00	8,634,950.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	3,020,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,574,400.00	3,693,850.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	215,915,313.42	175,368,572.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	215,915,313.42	175,365,572.60
392	Биет хөрөнгө	211,595,313.42	171,048,572.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,400,000.00	29,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,108,333.21)	(20,008,333.17)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	437,660,979.61	471,918,659.61
39206	Хуримтлагдсан элэгдэл	(244,807,332.99)	(311,961,753.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,774,411.50	34,774,411.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,324,411.49)	(33,074,411.53)
393	Биет бус хөрөнгө	4,320,000.00	4,320,000.00
39301	Программ хангамж	7,043,200.00	7,043,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,043,200.00)	(7,043,200.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,320,000.00	4,320,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	316,815,021.42	333,645,609.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	152,182.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	152,182.80
414	Урьдчилж орсон орлого	00.00	152,182.80
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	00.00	152,182.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	316,815,021.42	333,493,426.59
51	Засгийн газрын хувь оролцоо	316,815,021.42	333,493,426.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,320,000.00	4,320,000.00
51101	Өмч: - төрийн өмч	4,320,000.00	4,320,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	312,495,021.42	329,173,426.59
51210	Өмнөх үеийн үр дүн	318,717,383.81	318,717,383.81
51220	Тайлант үеийн үр дүн	(6,222,362.39)	10,456,042.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	316,815,021.42	333,645,609.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,266,628,290.04	2,332,299,305.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	118,355,490.04	94,986,528.14
120	Нийтлэг татварын бус орлого	118,355,490.04	94,986,528.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,355,490.04	94,746,528.14
120017	Үнэ төлбөргүй орлого/үндсэн хөрөнгө/	52,827,970.04	16,533,948.14
120018	Үнэ төлбөргүй орлого/бараа материал/	51,614,520.00	78,212,580.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,913,000.00	
120009+140020	Бусад орлого		240,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,148,272,800.00	2,237,312,777.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,139,248,800.00	1,939,443,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,139,248,800.00	1,935,523,400.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	3,920,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,024,000.00	297,868,977.70
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	2,310,000.00	192,570,277.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,714,000.00	105,298,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,254,040,652.43	2,315,620,900.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,254,040,652.43	2,315,620,900.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,214,348,754.43	2,033,289,118.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,658,500.00	1,601,369,619.67
210101	Үндсэн цалин	649,843,582.26	928,258,772.47
210102	Нэмэгдэл	203,844,754.02	506,294,572.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,970,163.72	150,301,275.00
210104	Урамшуулал	26,000,000.00	16,515,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,357,400.00	188,144,413.85
210201	Тэтгэврийн даатгал	93,051,000.00	129,515,819.05
210202	Тэтгэмжийн даатгал	11,476,600.00	14,661,686.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,621,300.00	7,332,294.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,655,300.00	7,325,760.95
210205	Эрүүл мэндийн даатгал	16,553,200.00	29,308,852.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,723,200.00	20,640,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,363,200.00	2,440,000.00
210302	Түлш, халаалт	3,829,700.00	15,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,418,000.00	1,200,000.00
210304	Байрны түрээс	112,300.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,250,717.00	11,365,139.20
210401	Бичиг хэрэг	11,726,520.00	8,916,425.00
210402	Тээвэр, шатахуун	2,695,000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,497,540.00	1,491,964.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,331,657.00	356,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,695,000.00	7,811,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	950,000.00	407,440.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	7,360,200.00
210604	Урсгал засвар	2,745,000.00	44,000.00
	Томилолт, зочны зардал		740,000.00
210702	Дотоод томилолтын зардал		740,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,114,034.20	41,829,117.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	1,089,100.00	1,625,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	92,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,410,900.00	590,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	34,614,034.20	39,399,267.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,549,903.23	161,389,188.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,914,000.00	102,868,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,440,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,335,903.23	57,080,688.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,691,898.00	282,331,781.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,747,700.00	241,741,911.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,947,700.00	37,874,111.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		201,455,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,412,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,944,198.00	40,589,870.99
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	2,944,198.00	40,589,870.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,587,637.61	16,678,405.17
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,810,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	18,810,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(18,810,000.00)	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(6,222,362.39)	16,678,405.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,488,222,062.10	2,628,850,373.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	339,949,262.10	391,537,595.75
120	Нийтлэг татварын бус орлого	339,949,262.10	391,537,595.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	339,949,262.10	391,297,595.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	339,949,262.10	391,297,595.75
120009+140020	Бусад орлого		240,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,148,272,800.00	2,237,312,777.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,139,248,800.00	1,939,443,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,139,248,800.00	1,935,523,400.00

131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	3,920,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,024,000.00	297,868,977.70
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	2,310,000.00	192,570,277.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны	6,714,000.00	105,298,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,488,408,061.80	2,628,698,190.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,488,408,061.80	2,628,698,190.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,380,902.00	1,955,220,995.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	937,658,500.00	1,604,429,371.61
210101	Үндсэн цалин	649,843,582.26	929,495,071.46
210102	Нэмэгдэл	203,844,754.02	508,118,025.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,970,163.72	150,301,275.00
210104	Үр дүнгийн урамшуулал	26,000,000.00	16,515,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,357,400.00	195,642,659.00
210201	Тэтгэврийн даатгал	93,051,000.00	137,014,065.10
210202	Тэтгэмжийн даатгал	11,476,600.00	14,661,686.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,621,300.00	7,330,842.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,655,300.00	7,327,212.95
210205	Эрүүл мэндийн даатгал	16,553,200.00	29,308,852.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,723,200.00	20,640,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,363,200.00	2,440,000.00
210302	Түлш, халаалт	3,829,700.00	15,800,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,418,000.00	1,200,000.00
210304	Байрны түрээс	112,300.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,730,802.00	19,726,674.20
210401	Бичиг хэрэг	11,586,605.00	14,747,310.00
210402	Тээвэр, шатахуун	2,695,000.00	2,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,581,540.00	1,491,964.20
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,867,657.00	867,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,397,000.00	6,026,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,144,000.00	2,354,440.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,253,000.00	3,672,000.00
2107	Томилолт, зочны зардал		740,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	740,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,500,000.00	2,429,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,089,100.00	1,625,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	92,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,410,900.00	590,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,014,000.00	105,586,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,714,000.00	104,146,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,440,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	380,027,159.80	673,477,194.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,947,700.00	241,741,911.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,947,700.00	37,874,111.00
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		201,455,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,412,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	343,079,459.80	431,735,283.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	331,825,009.10	391,145,412.95
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	11,254,450.70	40,589,870.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(185,999.70)	152,182.80
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(185,999.70)	152,182.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(185,999.70)	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	152,182.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	4,320,000.00	00.00	67,044,607.10	71,364,607.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,130,875.81	8,130,875.81
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,320,000.00	00.00	75,175,482.91	79,495,482.91
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	50,380,570.02	50,380,570.02
8	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,320,000.00	00.00	312,495,021.42	316,815,021.42
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,320,000.00	00.00	312,495,021.42	316,815,021.42
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,320,000.00	00.00	312,495,021.42	316,815,021.42
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	16,678,405.17	16,678,405.17
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,320,000.00	00.00	329,173,426.59	333,493,426.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,935,523,400.00	1,896,344,629.42	39,178,770.58	97.98

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,935,523,400.00	1,896,344,629.42	39,178,770.58	97.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,693,255,600.00	1,654,602,718.42	38,652,881.58	97.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,469,346,800.00	1,431,694,954.22	37,651,845.78	97.44
210101	Үндсэн цалин	831,934,000.00	806,361,827.51	25,572,172.49	96.93
210102	Нэмэгдэл	462,152,800.00	458,516,851.71	3,635,948.29	99.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	158,400,000.00	150,301,275.00	8,098,725.00	94.89
210104	Урамшуулал	16,860,000.00	16,515,000.00	345,000.00	97.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,904,800.00	171,904,800.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	120,860,000.00	120,860,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,761,200.00	12,761,200.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,380,600.00	6,380,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,380,600.00	6,380,600.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,522,400.00	25,522,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,640,000.00	20,640,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	2,440,000.00	2,440,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	15,800,000.00	15,800,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
210304	Байрны түрээс	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,384,000.00	19,726,674.20	657,325.80	96.78
210401	Бичиг хэрэг	15,260,000.00	14,747,310.00	512,690.00	96.64
210402	Тээвэр, шатахуун	2,620,000.00	2,620,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,504,000.00	1,491,964.20	12,035.80	99.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,000.00		20,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	980,000.00	867,400.00	112,600.00	88.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,165,000.00	6,026,440.00	138,560.00	97.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,380,000.00	2,354,440.00	25,560.00	98.93
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	105,000.00		105,000.00	-
210604	Урсгал засвар	3,680,000.00	3,672,000.00	8,000.00	99.78
2107	Томилолт, зочны зардал				
210702	Дотоод албан томилолт	740,000.00	740,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,635,000.00	2,429,850.00	205,150.00	92.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,625,000.00	1,625,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	-	100.00


210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	92,750.00	7,250.00	92.75
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30,000.00	22,000.00	8,000.00	73.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	780,000.00	590,100.00	189,900.00	75.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,000.00	1,440,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,000.00	1,440,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	242,267,800.00	241,741,911.00	525,889.00	99.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	242,267,800.00	241,741,911.00	525,889.00	99.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,400,000.00	37,874,111.00	525,889.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	201,455,800.00	201,455,800.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,412,000.00	2,412,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,939,373,400.00	1,939,373,400.00	00.00	102.89
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,939,373,400.00	1,939,373,400.00	00.00	99.80
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,939,373,400.00	1,939,373,400.00	00.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	152,182.80	(152,182.80)	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	48.00	48.00	0.00	100
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00	0.00	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	301,789,377.7	300,618,277.29	1,171,100.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,789,377.7	300,618,277.29	1,171,100.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,789,377.7	300,618,277.29	1,171,100.41
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,658,440.3	172,734,417.39	1,924,022.91
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	21,832,237.4	23,737,859.90	(1,905,622.5)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,298,700.00	104,146,000.00	1,152,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	105,298,700.00	104,146,000.00	1,152,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	301,789,377.7	301,789,377.70	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс			-

	тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	196,490,677.7	196,490,677.7	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,298,700.0	105,298,700.0	



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /цаашид Улсын бүртгэлийн хэлтэс гэх/ нь “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулах,
- Хэлтсийн албан хаагчдыг төрийн захиргааны удирдлагаар хангаж, бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд ил тод, чирэгдэлгүй хүргэх,
- Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхжуулах.
- Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах,
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн цахим санг ашиглах,
- Улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах,
- Суманд бүртгэгдсэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийг төв сүлжээнд шууд дамжуулж, мэдээллийн санг бүрдүүлэх,
- Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

УБХ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас дотоод хяналт тавьдаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс нь ХЗДХ-ийн сайдын 2020 оны 5 дугаарын сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,830.6 мянган төгрөгөөр буюу 5.31 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	152.2	152.2
Авлага	-	10,557.9	10,557.9
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Бараа материал	100,899.7	147,566.9	46,667.2
Үндсэн хөрөнгө	215,915.3	175,368.6	(40,546.7)
Нийт хөрөнгө	316,815.0	333,645.6	16,830.6
Өр төлбөр/урьдчилж орсон орлого	-	152.2	152.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	316,815.0	333,493.4	16,678.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	316,815.0	333,645.6	16,830.6

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 152.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь арилжааны банкин дахь үйлчилгээний орлогыг төсвийн дансанд төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансны үлдэгдэл 10,557.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан нийгмийн даатгалын шимтгэлийг 12-р сард давхардуулан шилжүүлснээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 147,566.9 мянган төгрөг болж 46,667.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 33,401.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 78,212.6 мянган төгрөгийн бараа материалыг УБЕГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан болон 64,946.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 175,368.6 мянган төгрөг болж 40,546.7 мянган төгрөгөөр буурсан нь УБЕГ-аас 34,257.7 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авч, 74,804.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 820,460.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт 533,547.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,354,008.1 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 488,163.3 мянган төгрөгөөр,
- ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 61,020.5 мянган төгрөгөөр,

- байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,890.0 мянган төгрөгөөр,
- хангамж, бараа материалын зардлыг 5,384.0 мянган төгрөгөөр,
- бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардлыг 300.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол,
- эд хогшил, урсгал засварын зардлыг 1,050.0 төгрөгөөр,
- томилолт, зочны зардлыг 2,260.0 мянган төгрөгөөр,
- бараа үйлчилгээний бусад зардлыг 360.0 мянган төгрөгөөр,
- бусад урсгал шилжүүлгийн зардлыг 30,540.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан гэх.мэт



Тайлант оны батлагдсан төсөвт дараах байдлаар тодотгол, зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

Цалин хөлс, нэмэгдэл урамшуул, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 340,207.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 241,307.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, **1,935,523.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,935,523.4** мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,896,344.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,896,344.6 мянган төгрөг буюу 98.0 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 37,651.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 657.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 138.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 205.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 525.9 мянган төгрөгөөр гэх мэт батлагдсан төсвийг нийт **39,178.8** мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,693,255.6	1,654,602.7	38,652.9	97.7
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	242,267.8	241,741.9	525.9	99.7
	Нийт	1,935,523.4	1,896,344.6	39,178.8	98.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар УБЕГ-аас УИХ-ын ээлжит сонгууль болон АНСДИТХ -ын ээлжит сонгууль зохион байгуулах зардалд 105,298.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд 192,570.3 мянган төгрөг, Ерөө сумын Засаг даргын нөөцөөс орон нутгийн нэмэгдэл 3,920.4 мянган төгрөг зэрэг нийт 301,789.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 300,618.3 мянган төгрөгийг дараах зардалд зориулалтын дагуу зарцуулан, 1,171.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

- УИХ-ын ээлжит сонгууль болон АНСДИТХ-ын ээлжит сонгуулийн хэсгийн хороодын итгэмжлэгдсэн ажилтнуудын урамшуулал, албан томилолт, шатахуун болон бусад зардалд 104,146.0 мянган төгрөг,
- Тус хэлтсийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд 196,472.3 мянган төгрөг,

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,254,040.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,540.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, кино контент, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн цалингийн урьдчилгааг давхардуулан тайлагнаж, НДШ, ХХОАТ-т 7,700.4 мянган төгрөгийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн гэж мэдээлсэн боловч авлага үүсгэсэн зөрчил давтагдсан гарсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	7,700.4			
Нийт дүн	1	7,700.4			

Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч М.Мягмарт **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **10,764.3** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 2 албан шаардлага бичигдлээ.

5.1 Албан шаардлага

1.Багаж, техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд **206.4** мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

2.Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас нийгмийн даатгалын шимтгэлийг 12-р сард давхардуулан шилжүүлж **10,557.9** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх *“...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах*

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч М.Мягмарт **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
НДШ илүү шилжүүлж, авлага үүсгэсэн зөрчлийг давтан гаргасан.	1	10,557.9							1	1		
Төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй.	1	206.4			1	206.4						
Дүн	2	10,764.3			1	206.4			1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн						
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	-	-						
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт дүн	-	-						



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 33/А1871319
СЭА-2025/089/НА-СТА-ТШЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар багаж, техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд 206.4 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.6 "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Саранчимэг, нягтлан бодогч М.Мягмар нарт даалгав

432504097

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Э.ЭНХБҮРЭН



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 32/А 1871319
СЭА-2025/089/НА-СТА-ТШЗ

Сүхбаатар

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс дараах зөрчлийг давтан гаргасан зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас нийгмийн даатгалын шимтгэлийг давхардуулан шилжүүлж, 10,557.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.2 -д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ахлах нягтлан бодогч М.Мягмарт холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Саранчимэгт даалгав.

432504094

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Э.ЭНХБҮРЭН